

## МАЛЧИН АЙЛЫН НУТАГШИЛ НҮҮДЭЛЛЭХ ЁСНЫ УЛАМЖЛАЛ

Г.ЦЭРЭНХАНД  
*МУИС-ийн Угсаатны зүйн тэнхим*

Монгол малчдын үеэс үед улируулан хөгжүүлж ирсэн нэгэн ололт бол “оршин зохицохуйн” байгаль орчны тухай мэдлэг ухааны уламжлал билээ. Цаг хугацааны ихэнхийг малын дэргэд хөдөө хээр өнгөрөөдөг монголчууд нутаг нуга, газар усныхаа бичил уур амьсгал, ургамал, амьтны аймаг, хөрс широо, ус ундны байрлал зэргийг танин ойлгон хүн, малд ямар нөлөөтэй болохыг ухаарч ахуй амьдралаа зохицуулж иржээ. Нүүдэлчдийн хувьд идээшин дассан нутаг бол амьдрах орчин болдог. Иймээс малчин хүн нутаглаж байгаа газрын тухайдаа малын бэлчээрийг нэгтгэсэн хам ойлголттой байдаг. Өөрөөр хэлбэл хүн, мал, бэлчээр нэгдэж нутагших орон зайг үүсгэж манай нутаг-өтөг бууц хэмээн нэрлэгддэг аж. Малчин хүний өдөр тутмын хэллэгт нутаг бэлчээр, нутаг ус, тэднийхэн Цохиотын аманд буужээ, Жаргалантын худаг төчнөөн айлтай гэхчлэн яригддаг. Нүүдэлч-малчид хот айлын хэлбэрээр төвлөрч буух ба малын бэлчээр нь эргэн тойрон ойролцоогоор 30 км орчимд байна. Малчин хүн бэлчээрийн газар хэмээх ойлголтыг малын бэлчээрлэх зайг баримжаалан тоймлон тогтоож заншсан аж. Үүнд таван хушуу малын хол, ойр бэлчээрлэн явах чадварыг харгалзан адуу, тэмээ, үхрийг урт хөлт бод мал, хонь, ямааг богино хөлт бод мал гэж ялгана. Бод, бод малын ба төлийн бэлчээр гэж нэрлэдэг талаар ардын домог түүхэнд цөөнгүй тусгагдсан байдаг юм. Жишээлэхэд “бярууны бэлчээрээс хол газар яваагүй, босгоноос өндөр даваа даваагүй хүн” гэж зүйрлэн хэлсэн үг ч буй. Ийнхүү айлын нутагшил аль хир хэмжээний газар нутгийг хамарсан байх нь жилийн дөрвөн улирал ба газар орчны байрлалаас үндэслэн харьцангуй ойлголт гэж болно. Гэхдээ энэ бол нүүдэл ахуй, нүүдэл иргэншлийг танин мэдэхэд маш чухал зүйл гэлтэй. Тухайлбал, уулархаг нутагтай Хөвсгөл аймгийн Дархад ардын дунд “Морины аргамжааны газар /25-30 м/, хонины бэлчээрийн газар /1-2 км/, үхрийн бэлчээрийн нутаг /2-2,5 км/, тугалын бэлчээр /нэг км орчим/, хурганы бэлчээр/ 500 м-ээс нэг км/, адууны бэлчээр /4 км орчимоор/ тус тусыг тоймлосон байдаг<sup>21</sup> бол говь, тал хээрийн бүс нутагт ч иймэрхүү /хол, ойрын зай/ төсөөлөлтэй байх нь ажиглагддаг.

Нутагшил-нутаглах “нутагшин дасах” орчин буюу малчин айлын өвөлжих “өтөг бууц”, хаваржих “хөх бууц”, намаржих нутаг нь мал маллагааны онцлог, улирлын байдалд зохицсон нүүдэл ахуйг бүрэн тусгасан ухагдахуун юм. Монголчуудын бэлчээрийн мал аж ахуйн өвөрмөц тал нь цаг улирлын аясаар нутаг сэлгэж өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржaa гэсэн нүүдэл ахуйн бүхэл бүтэн “эргэлт” нутагшлийг буй болгожээ. Малчдын нутагшил газар зүйн бүсчлэлийн байдлаас хамаарч өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Малчид хоорондоо цаг улиралтай холбогдуулан нутаг хаана вэ? хаана өвөлжиж, хаваржиж, зусч, намаржиж байгаа талаар үг үүсгэж, тэднийх тэнд өвөлжиж байгаа, тэдний хуучин өвөлжөө Нарийны аманд шүү дээ гэх мэтээр хуучилдаг. Жилийн дөрвөн улиралд малчин айлын хамгийн удаан хугацааны нутагшин суух газар бол өвөлжөө юм. Өвлийн улирал гэдэг малчдын хувьд хамгийн нэсөр, хатуу бэрх цаг хугацаа учир олон талын мэдлэг ухааны уламжлал, ажлын туршлага, авхаалж самбааг шалгах үе юм. Үүнд, малчин айл нутаглах орчноо таньж мэдсэн байхаас гадна амьдрах ахуйгаа зохицуулж, өвлийн дүн хүйтэн үед мал сүргийн арчилгаа маллагаанд анхаарлаа хандуулсан бүх боломжийг хангадаг байж.

<sup>21</sup> С.Бадамхатан. Хөвсгөлийн дархад ястан. УБ., 1965. тал 195

Монгол орны ихэнх нутагт өвлийн хүйтнийг онцгойлон үзэж байсан учир “гунан үхрийн эвэр хуга хөлдөм гурван ес” гэх уламжлал тогтжээ. Идэр есийн үед цан хүүрэг татаж, малын хэвтэр хөлддөгөөс ардын дунд “дулаан хэвтэш, дунд идэш” гэдэг зүйр үг гарчээ. Энэ бол дулаан хэвтэр бууц малын тэжээлтэй эн зэрэгцэх ач холбогдолтойг үнэлсэн үнэлгээ юм.

Малчин айлын өвөлжөө бууц – нутагшил гол төлөв хүйтэн жавар салхины урсгалгүй, цас хөрлөж тогтохгүй, амархан цоохортож идэш гардаг, малд шимтэй өвс ихтэй, өглөө нар эрт тусаж, орой эрт хүүшилдэггүй, уулын өвөр, эсвэл салхи жаврын дээд талд хэсэг хэсэг хөндлөн хяр, сэrvэн зэрэг нөмөртэй тавиу нутаг,.govьд бол харгана бут элбэгтэй орчинд байжээ. Тухайн орчны салхи жаврын урсгал өдөр өдөрт өөрчлөгдж байдаг боловч малчин хүн олон жилийн турш салхи жаврын урсгалыг “өглөө үүрийн жавраар, орой нарны жавраар” ажиглаж, мөн хүйтэн жавар салхитай өдөр айлын утаа /ихэнх тохиолдолд/ салхинд давтуулахгүй алгуур гарч байвал тэр газрыг хүйтэн салхины урсгал багатай бууц хэмээн тогтоож, иймэрхүү нөмөр нөөлөг нутагшлыг үеэс үед дамжуулан өвөлждөг заншилтай. МНТ-д “Нуган хүү нутгаа” гэдэг нутаг, нутагшлын тухай маш нарийн утга агуулгатай ойлголт тусгагджээ. Нутаг усаа хамгаалан хайлаж манай эцэг өвгэдийн нутаглаж байсан өгөөжтэй, элбэг баян, өнтэй нутаг хэмээх малчин хүний сэтгэхүй бодол нь угтаа тухайн орчин байгалиа мэдэж, түүнтэй зохицож, малаа өсгөж, амьдралаа болгож байсны гэрч гэж болно. Монголчууд нутаглах бууцаа гол төлөв уг газрын аль тогтвортой онцлог хийгээд уул хад, ам жалга, гол усны нэрээр буюу Цагаан чулуут, Хужирт, Жаргалантын өвөлжөө гэхчилэн шууд зааж нэрлэх заншил нь эртнээс уламжлалтай юм.

Жилийн аль ч улиралд малчин айлууд гэрийн үүдээ өмнө зүг хандуулан алсын бараатай налгар уул руу чигтэй, голын урсгал сөрсөн эх рүү маягтай, хотоо тойрч дугуйрсан байдааар /эсвэл хотны шанаагаар/ малаа хамгаалж гэрээ барьдаг ба нар эхлэж тусах баруун зүгийг эрхэмлэх заншилтай. Хотонд бог мал нэг хэвтэртэй байдаг учир түүгээр нь хот айл гэж нэрлэгдэх болсон ба бусад мал тус тусдаа хэвтэш, зэлтэй байна. Харин гэрийн үүдийг уулын хөтөл, ам, усны тохой, урсгалын уруу, зам голлуулахыг цээрлэж байжээ. Мал сүргийн дотроос адууг эрхэмлэн хүндэтгэхтэй уялдан, хот айлд морины уяаг салхины дээр гэрийн баруун, баруун урьд чигт босгох заншил тогтож, ойрад монголд гэрийн баруун талаас морины жолоог хавчуулах ёс одоо хүртэл уламжлагдаж байгаа аж. Ийнхүү манай малчдын нүүдэллэн аж төрж ирсэн түүх бол хотлон айлсах, саахалтаар нутаглах соёлыг бүтээжээ. Ялангуяа байгаль, цаг уурын тодорхой бүс нутагт ямар малд ямар өвс ургамал тохирдог, нутагшлыг хэрхэн яж сонгох дэг журам болон мал маллагааны арга ажиллагаа нь үеэс үед уламжлан амьдралын туршлагаар баяжиж эдүгээ хүрчээ. Угсаатан судлалын хээрийн судалгааны материалыг үндэслэвлээвэл эцэг, хүүхдийн ба садан төрлийн өрхүүд нэг хот айлыг үүсгэх нь зонхилох төлөвтэй боловч амьдралын шаардлага, аж ахуйгаа хөтлөх арга ажиллагаанаас хамаарах явдал нилээд байжээ. Хот айлын агуулга, чиглэлийг киргиз, казакын “аул”, индиан кечуачуудын “айлью”-тай адилтгах тал байгаа ч гэсэн өмч хөрөнгөний нэгдэл суурьлаагүй өөрийн өвөрмөц түүхтэй юм. Айл хотын бүтэц бүрэлдэхүүн нь монгол нутгийн газар зүйн онцлогтой уялдан харилцан адилгүй, хангайн бүсэд 3-5 гэрээр хотлон нутагшиж байхад, тал хээр болон.govьд ганц хоёр гэрээр аж төрлөө зохицуулах нь нийтлэг үзэгдэл билээ.

Хот айлаар болон саахалт буух хэлбэрээр<sup>2</sup> айлсах нутагшил нь юуны өмнө бэлчээр нутгийг хамтран ашиглах, малаа ээлжлэн хариулах, хүнд хүчир ажлаа хамтран гүйцэтгэхийн зэрэгцээгээр дэм дэмэндээ эд материалын талаар харилцан

<sup>2</sup> Саалийн үед хурга, ишгээ зөрүүлж хариулах /харилцан туслах/ мал маллагааны арга /саахалтын газар 1,5-2,5 км/

туслалцах, сэтгэл санааны нийтлэг сонирхолд оршиж байв. Нутагшилд айл хотын ахлагч, ахмад хүмүүсийн үүрэг их байсан бөгөөд хойч ўе, үр хүүхдийн хүмүүжих орчин, нарийн зохион байгуулалттай нийгмийн нэгж болж, аж төрөхийн бичигдээгүй хууль үйлчилж байсан нь тодорхой билээ. Айл хотын тухай ахмад түүхч Ц.Насанбалжир “Малчин ардууд хэдэн сар буюу жилээр нэг хот айл, саахалт хотоор бууж, нэгэн бэлчээр усанд нутаглах, салж нүүх, тэдгээр айл өрхүүд өөр айл өрхтэй нийлж ..... дахин шинэ хот айл, саахалт хот /үүсгэж нутаглах нь - Г.Ц/- оор буух нь мал аж ахуйтан ардуудын өөрсдийн сайн дурын хэрэг байсан” гэж бичжээ<sup>3</sup>. Ер нь мал аж ахуй эрхлэх, мал маллагааны арга ажиллагаанд харилцан бие биедээ ижил дасал болсон айл өрхүүд /заавал төрөл садан, эцэг хөвгүүд байх албагүй/ нэгдэж бэлчээр нутгаа зохицуулан нутагших нийтлэг заншил, уламжлалтай байжээ. Малчдын нүүдэл бол байгаль—цаг уурын өөрчлөлт мөчлөгтэй салшгүй холбоотой бэлчээрийн мал аж ахуй эрхэлж амьдрал байдлаа зохицуулах үндсэн арга юм. Иймээс ч нүүдэллэх ёс нь олон талын утга агуулга бүхий аж төрөх мэдлэг ухааны уламжлал болно. Нүүдэл бол бэлчээр хамгаалах, малын тарга тэвээргэнд ашигтай бөгөөд талхлагдсан бэлчээр өвчний нян үүсгэх аюултай гэдэг байв. Малчин айл шинэ нутаг, сэргүүн бэлчээрт нүүж бууна гэдэг монгол хүний сэтгэл зүйд баяр баясгалан хүндэтгэл хэмээн ойлгогдож, ачаа хөтлөх гэрийн эзэгтэй “авгай хүний” бүрэн хэрэглэлээ зүүн, өнгөтэй өөдтэй гоёлын хувцсаа өмсдөг ба нүүдлийн замд ойр байгаа айл шинэ цай хийж, идээ ундааг нүүдэл тосч өгдөг хэвшил болсон заншил байжээ. Нүүдлийг ачаалахад бэлгэдлийг ихэд анхаарч, эхний тэмээ /үхэр тэрэг/-нд юуг ачааллах, адагт нь ямар ачаа бараа явах нарийн ёс журам баримталдаг байжээ.

То-ван /Сэцэн хан аймгийн Тогтохтөр ван-/ийн сургаалд<sup>4</sup> “Бэлчээрийг зөв сонгох, малд зохих цагт нь тарга хүч авахуулахад олон удаа нүүхийг чухалчилсан байдаг. Ерөнхийдөө улирлын нутагшлыг дагаж, малчин айл жилд харилцан адилгүй орон зайд нүүдэллэж байсан нь ойлгомжтой. МНТ-д “...адууны бэлчээрийг дагаж ууланд шахаж буух ... хонины бэлчээрийг дагаж голд шахаж буух”<sup>5</sup> талаар гардаг нь эртнээс нааш монголчууд мал малын төрөлд бэлчээрийг тохируулан нүүдэллэж байсны улбаа гэж үзэх боломжтой.

Бүс нутгийн онцлогтой уялдуулан нүүдлийг уулын,.govийн, тал хээрийн гэж хэлбэржүүлэн нэрлэх нь буй. Гэхдээ бэлчээр дагах нүүдэл нь улирлын чанартай ба отор хийх байдлаараа хоорондоо ялгагдаж болно. Тухайлбал, улирлын нүүдэл гэдэг нь хаврын уур орох үед өвлүүн өтөг бууцнаас гарч “өл залгах” хаврын бэлчээрт хаваржаалан, хөх униар татсан, хөх ногооны шим дагаж зусч нүүдэллэх мөн намаршин өвс гандаж, намрын шинжтэй болоход малынхаа тарга хүчийг тогтоох нүүдэл хийж, өвлүүн бэлчээр, нутаг бууцандaa ойтдог байна.

Отор нүүдэл бол мал маллагааны бас нэг арга бөгөөд хаврын хатуу улиралд малаа сувайлж, холын бэлчээрийн нялх ногоонд оторлох, зун нь малд тарга хүч авахуулах соргог бэлчээрийн отор хийх, намар нь ногооны сөл хөөж давхар тарга суулгахаар оторлох, өвөл нь зуд турханы байдлаас хамааран нөөц бэлчээрт оторлоно. Отор бол малын бэлчээр, ус, хужирыг тохируулах, орчин тойрны ургамлын бүтэц, тархалтыг тогтоох зэрэг олон талын ач хобогдолтой нүүдэл ёсны уламжлал болно.

Малчин айлууд цаг улирлын байдлаар тогтсон нутагшлын дагуу нүүдлээ зохицуулж байдаг нь дээр өгүүлснээс илэрхий болно. Нүүдэл, нүүдэллэх ёс заншил

<sup>3</sup> Ц.Насанбалжир. Монголын аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэтгэл /XIX зууны эцэс XX зууны эхэн/ УБ., 1978. тал 8

<sup>4</sup> Ш.Нацагдорж. То ван, түүний сургаал. МН. (Сурвалж судлах) 1968. тал 41-42

<sup>5</sup> Монголын нууц товчоо. УБ. (118) 1990.

тухайн бус нутгийн онцлогтой шууд холбоотой. Тухайлбал, хангай нутгийн малчид зуны цагт гол усандaa ойртож нүүдэг бол Алтай нутгийн урианхай, Торгууд, Захчин, Дөрвөд зэрэг монгол угсаатны бүлгүүд уулын нүүдлийн хэлбэрээр өндөрлөг нутагтаа зусч, өвлийн улиралд уулын бэл орчмоор нүүдэллэн өвөлждөг талаар угсаатан судлалын ном хэвлэлд тодорхой бичигджээ.

Эцэст нь тэмдэглэхэд монгол малчид амьдрах орчныхоо талаар арвин туршлага, мэдлэгтэй байсан нь үеэс үеэд уламжлан хадгалагдаж оршин зохицохуйн ёс заншлаар аж төрлөө зохицуулж, нутагшил, нүүдлийн totson дэг ёс, соёлтой байжээ.